Нүүрний үрчлээнд гуаша эмчилгээний зарим үр дүн

Б.Болорчимэг[1], Я.Энхтөр[2], З.Болортулга[1]

[1]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт эмчилгээний тэнхим
[2]АШУҮИС, Төгсөлтийн сургалтын алба
Цахим шуудан: bolorchimeg.official@gmail.com, Утас: 99705008

Түлхүүр үг:

Нүүрний гуаша
Нүүрний үрчлээ
Нөлөөлөх хүчин зүйл
Нас

Товч утга:

Үндэслэл: Орчин үед эмэгтэйчүүд нүүрний үрчлээнд ихээхэн анхаарал хандуулж үрчлээ арилгах төрөл бүрийн аргыг хэрэглэж байна. Эдгээр аргууд нь мэс заслын болон сөрөг нөлөө ихтэй байна. Иймд бид судалгаандаа мэс заслын бус, сөрөг нөлөөгүй уламжлалт анагаах ухааны нүүрний гуаша эмчилгээг нүүрний үрчлээнд нөлөөлөх үр дүнг судлах нь бидний судалгааны үндэслэл болж байна. **Зорилго:** Нүүрний үрчлээнд гуаша эмчилгээний үр дүнг судлах. **Арга, аргачлал:** Бид судалгаандаа нийт 60 үйлчлүүлэгчийг хамруулан гуаша эмчилгээний бүлэг, харьцуулах нүүрний иллэгний бүлэг болгон 2 бүлэгт хувааж (Lemperle scale-ийн) 5 онооны үнэлэлтийн аргаар үрчлээг тодорхойлон хэмжиж үнэлсэн. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид бүлэг тус бүрийн эмчилгээг үргэлжлэх хугацаа 15-20 минутаар 7-10 удаа буюу 1 курс хийлгэв. **Үр дүн:** Бидний судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн баруун нүдний гадна хажуугийн үрчлээ гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 15 (50%), мэдэгдэхүйц үрчлээ 8 (26.67%) болж үрчлээ арилсан байна. Өнгөц үрчлээ 4 (13.33%), дунд зэргийн гүн үрчлээ 3 (10%), гүн үрчлээ нь тод илрэхгүй 0 (0%) болж үрчлээ багассан үр дүн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. (p= 0.0001***) Зүүн нүдний гадна хажуугийн үрчлээ гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 14(46.67%), мэдэгдэхүйц үрчлээ 9 (30%), үрчлээ арилсан байна. Өнгөц үрчлээ 3 (10%), дунд зэргийн гүн үрчлээ 3 (10%), гүн үрчлээ тод илэрхий 1 (3.33%), маш гүн үрчлээнүүд нь үрчлээ багассан ажиглагдаж буй нь статистик ач холбогдол өндөртэй байлаа. (p= 0.0001***) Духны хэсгийн үрчлээ гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 19 (63.33%), мэдэгдэхүйц үрчлээ 9 (30%), өнгөц үрчлээ 2 (6,67%), дунд зэргийн гүн үрчлээ 0 (0%) болж үрчлээ арилж статистик ач холбогдол өндөртэй байлаа. (p= 0.0001***) **Дүгнэлт:** 1. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн баруун болон зүүн нүдний гадна хажуугийн үрчлээ, духны хэсгийн үрчлээнд үрчлээгүй, мэдэгдэхүйц үрчлээ, өнгөц үрчлээнд гуаша эмчилгээ үр дүн өндөртэй болохыг тогтоов. Харин дунд зэргийн гүн үрчлээнд тодорхой хугацааны дараа үр дүн үзүүлсэн боловч, гүн үрчлээнд үр дүн илэрсэнгүй. Иймд нэг курс эмчилгээ хангалтгүй байсан гэж үзэж байгаа бөгөөд цаашид курс эмчилгээг тууштай хийвэл гүн үрчлээг арилгах магадлалтай гэж үзэж байна. 2. Нүүрний гуаша эмчилгээ нь иллэгтэй харьцуулахад нүүрний үрчлээгүй, мэдэгдэхүйц үрчлээ, өнгөц үрчлээнд эмчилгээний үр дүн өндөртэй байгаа нь цаашид гуаша эмчилгээг гоо сайхны салбарт хэрэглэх нь ач холбогдолтойг харуулж байна.

Үндэслэл: Сүүлийн үед хүний хөгшрөлтийг илэрхийлдэг гол хүчин зүйл бол арьсны хөгшрөлт юм. Иймээс арьсны эрдэмтэд, арьсны эмч нар арьсны хөгшрөлтийг илүү сонирхон судлаж, арьсны хөгшрөлтөөс урьдчилан сэргийлэх талаар олон тооны судалгаа хийгдсэн байна.Ихэнх судалгаанууд нүүрний арьсны үрчлээнд төвлөрдөг. Биеийг залуужуулах хүсэлтэй хүмүүс ч нүүр хүзүүний хэсгийн үрчлээнд анхаарлаа хандуулдаг. Ялангуяа эмэгтэйчүүд ихэвчлэн 25 наснаас эхэлж нимгэн жижиг үрчлээ, 30 наснаас духны үрчлээ гүн болж нэмэгдэн нүдний гадна дээд, доод буланд үрчлээс (crow's feet) үүсдэг. 40 наснаас хамар уруулын үрчлээ гүн болдог.[1] Нүүрний арьсны жинхэнэ арьсан давхаргын үндсэн хэсэгт торлог давхар

байдаг. Торлог давхрын 95%-ийг коллаген эзэлдэг бөгөөд коллагены хэмжээ багасч, холбогч эдийн уян ширхэгийн торон бүтэц эвдэрч үрчлээ үүсдэг.[2,4]

Нүүрний үрчлээг тайван үед болон нүүрний хувирал хийж байгаа байдлаар нь 2 төрлийн нөхцөлд үнэлдэг. Нүүрний үрчлээг өнгөц, дунд, гүн гэж 3 ангилдаг.[3] Хятадын уламжлалт анагаах ухааны нүүрний гуаша нь нүүр болон хүзүүний арьсны үрчлээ, нүдний доорх уутанцар, нүд тойрсон хөхрөлт, нүүрний нөсөө толбо, батга зэрэг арьсны нийтлэг эмгэгүүдийг эмчлэх энгийн, үр дүн хурдан гардаг, гаж нөлөөгүй эмчилгээний арга юм. Нүүрний гуаша нь зөвхөн нүүрний цусны судасны бичил эргэлтийг сайжруулаад зогсохгүй цус, лимф, биеийн шингэний урсгалыг нэмэгдүүлж, арьсны эд эсийг хангалттай тэжээл, хүчилтөрөгчөөр хангаж, эсийн бодисын солилцоог хурдасгаж, үхэжсэн арьсыг гуужуулах явцыг дэмжиж шинэ эсийн үүсэлтийг нэмэгдүүлдэг. Гуаша эмчилгээ нь арьсны доод дээд давхаргыг халааж, шинэ арьсны коллагены уян эластин/ ширхэгийн үүсэлтийг өдөөдөг. Энэ нь арьсыг чангалж, үрчлээг багасгадаг.

Гуаша нь нүүрний арьсанд шарх үүсгэдэггүй, гаж нөлөөгүй гэсэн хэдий ч судлаачид аюулгүй байдал, үр дүнтэй байдлын талаар нэмэлт судалгаа хийхийг зорьж байна.[11] Монгол орон эрс тэс сэрүүн уур амьсгалтай бөгөөд монгол эмэгтэйчүүдийн нүүрний үрчлээг судлахад судлаачдын сонирхлыг татаж ирсэн. Арьсны бүтэц онцлог, нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан олон тооны судалгаа байгаа хэдий ч нүүрний гуашаг үрчлээнд хийсэн судалгаа одоогоор хийгдээгүй байгаа нь энэхүү судалгааг хийх үндэслэл болж бна.

Зорилго: Нүүрний үрчлээнд гуаша эмчилгээний үр дүнг судлах

Зорилт:

1. Нүүрний духны болон нүдний гадна хажуугийн үрчлээнд гуаша эмчилгээний үр дүнг судлах
2. Нүүрний гуаша болон нүүрний иллэг эмчилгээний үр дүнг харьцуулан судлах

Арга, аргачлал: Бид судалгааныхаа ажлаа АШУҮИС-ийн МАУҮТЭмнэлэг, АШУҮИС төв эмнэлгийн амбулаторийн тасагт түшиглэн, эмнэлзүйн судалгааг санамсаргүй хяналтат эмнэлзүйн туршилт судалгааны загвараар дан нууцлалын аргыг ашиглан явуулав. Судалгаанд нийт 60 үйлчлүүлэгчийг хамруулан нүүрний иллэг болон гуаша эмчилгээний 2 бүлэгт хувааж үр дүнг нэгтгэн статистик боловсруулалтыг SPSS-22 программыг ашиглан хийж гүйцэтгэв.

Үр дүн: Бид судалгаандаа Улаанбаатар хотын БЗД-ийн 12-р хорооны МАУТЭ-ээр үйлчлүүлж буй 35-55 насны 60 эмэгтэйг хамруулаа. Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн нүүрний духны хэсэг болон нүдний гадна булангийн хажуугийн үрчлээний зургийг тайван үед эгц суугаа байрлалд авч (Lemperle scale-ийн) 5 онооны үнэлэлтийн аргаар үрчлээг тодорхойлон хэмжиж үнэлсэн. Үнэлгээг эмчилгээний өмнө болон дараа хийж гүйцэтгэв. Үрчлээнд гуаша эмчилгээг 7-10 удаа 1 курс эмчилгээ хийв.

Судалгааны явцад нийт 30 үйлчлүүлэгчдийн баруун нүдний гадна булангийн хажуугийн үрчлээнд гуаша эмчилгээг, 30 үйлчлүүлэгчид нүүрний иллэгийг тус тус 7-10 удаа, нэг удаад 15-20 минутаар хийж гүйцэтгэв.

Нүүрний үрчлээний гүн болон өнгөц шинж чанараас хамааран стаститик ач холбогдол харилцан адилгүй үр дүнг илтгэж байлаа. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн баруун нүдний гадна хажуугийн үрчлээ гуаша эмчилгээний өмнө үрчлээгүй 3 (10%), мэдэгдэхүйц үрчлээ 12 (40%), өнгөц үрчлээ 6 (20%), дунд зэргийн гүн үрчлээ 7 (23.33%), гүн үрчлээ тод илэрхий 2 (6.67%),байсан. Гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 15 (50%), мэдэгдэхүйц үрчлээ 8 (26.67%) болж үрчлээ арилсан байна. Өнгөц үрчлээ 4 (13.33%), дунд зэргийн гүн үрчлээ 3 (10%), тод гүн үрчлээ илрэхгүй болж үрчлээ багасаж үр дүн нь статистик ач холбогдол бүхий ялгаатай байлаа. (p= 0.0001***) (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Баруун талын нүдний гадна булангийн хажуугийн үрчлээнд гуаша эмчилгээний үр дүн

Үнэлгээ	Баруун нүдний гадна хажуу үрчлээ				P утга
	Гуаша эмчилгээний өмнө		Гуаша эмчилгээний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	3	10%	**15**	**50%*****	0.0001***
Мэдэгдэхүйц үрчлээ	12	40%	**8**	**26.67%****	
Өнгөц үрчлээ	6	20%	**4**	**13.33%****	
Дунд зэргийн үрчлээ	7	23.33%	**3**	**10%****	
Гүн үрчлээ тод илэрхий	2	6.67%	0	**0%**	
Маш гүн үрчлээ	0	0%	0	**0%**	

Тайлбар: *(p= 0.0001***)*

Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн зүүн нүдний гадна хажуугийн үрчлээ гуаша эмчилгээний өмнө үрчлээгүй 5 (16.67%), мэдэгдэхүйц үрчлээ 11 (36.67%), өнгөц үрчлээ 4 (13.33%), дунд зэргийн гүн үрчлээ 8 (26.67%), гүн үрчлээ тод илэрхий 1 (3.33%), маш гүн үрчлээтэй 1 (3.33%) байсан. Гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 14 (46.67%), мэдэгдэхүйц үрчлээ 9 (30%) болж үрчлээ арилсан байна. Өнгөц үрчлээ 3 (10%), дунд зэргийн гүн үрчлээ 3 (10%), гүн үрчлээ тод илэрхий 1 (3.33%), маш гүн үрчлээнүүд арилж, үрчлээ багассан нь статистик ач холбогдол бүхий байлаа. (p= 0.0001***) (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Зүүн талын нүдний гадна булангийн хажуугийн үрчлээнд гуаша эмчилгээний үр дүн

Үнэлгээ	Зүүн нүдний гадна хажуу үрчлээ				Р утга
	Гуаша эмчилгээний өмнө		Гуаша эмчилгээний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	5	16.67%	**14**	**46.67%*****	0.0001***
Мэдэгдэхүйц үрчлээ	11	36.67%	**9**	**30%****	
Өнгөц үрчлээ	4	13.33%	**3**	**10%****	
Дунд зэргийн үрчлээ	8	26.67%	**3**	**10%*****	
Гүн үрчлээ тод илэрхий	1	3.33%	1	3.33%	
Маш гүн үрчлээ	1	3.33%	0	0%	

Тайлбар: *(p= 0.0001***)*

Судалгааны үйлчлүүлэгчдийн духны хэсгийн үрчлээ гуаша эмчилгээний өмнө үрчлээгүй 7 (23.33%), мэдэгдэхүйц үрчлээ 12 (40%), өнгөц үрчлээ 8 (26.67%), дунд зэргийн гүн үрчлээ 3(10%), гүн үрчлээ тод илэрхий 0 (0%), маш гүн үрчлээтэй 0 (0%) байлаа. Гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 19 (63.33%), мэдэгдэхүйц үрчлээ 9 (30%), өнгөц үрчлээ 2 (6.67%), дунд зэргийн гүн үрчлээ 0 (0%) болж үрчлээ арилж статистик ач холбогдол өндөртэй байлаа. (p= 0.0001***) (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Нүүрний духны хэсгийн үрчлээний гуаша эмчилгээний үр дүн

Үнэлгээ	Духны хэсгийн үрчлээ				Р утга
	Гуаша эмчилгээний өмнө		Гуаша эмчилгээний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	7	23.33%	**19**	**63.33%*****	0.0001***
Мэдэгдэхүйц үрчлээ	12	40%	**9**	**30%*****	
Өнгөц үрчлээ	8	26.67%	**2**	**6.67%*****	
Дунд зэргийн гүн үрчлээ	3	10%	**0**	**0%*****	
Гүн үрчлээ тод илэрхий	0	0%	0	0%	
Маш гүн үрчлээ	0	0%	0	0%	

Тайлбар: (p= 0.0001***)

Баруун нүдний гадна хажуу үрчлээнд нүүрний гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 40%-аар үрчлээ арилж, мэдэгдэхүйц үрчлээ 13.33%, өнгөц үрчлээ 6.67%, дунд зэргийн үрчлээ 13.33%, гүн үрчлээ тод илэрхий 6.67%-аар багассан байлаа. Харин нүүрний иллэгийн дараах үр дүнгээр үрчлээгүй 0% буюу үр дүн мэдэгдэхгүй, мэдэгдэхүйц үрчлээ 3.34%, өнгөц үрчлээ 3.33%-аар багасаж, дунд зэргийн үрчлээ болон гүн үрчлээ тод илэрхий, маш гүн үрчлээнд 0% буюу үр дүн үзүүлээгүй байна. (p=0.001***) (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Баруун нүдний гадна хажуу үрчлээний нүүрний гуаша эмчилгээ болон иллэг заслын дараах харьцуулсан үр дүн

Үнэлгээ	Баруун нүдний гадна хажуу үрчлээ				Р утга
	Гуаша эмчилгээний дараа		Нүүрний иллэг хийсний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	12	**40%↑*****	0	**0%**	**0.001*****
Мэдэгдэхүйц үрчлээ	4	**13.33%↓***	1	**3.34%↓**	
Өнгөц үрчлээ	2	**6.67%↓**	1	**3.33%↓**	
Дунд зэргийн гүн үрчлээ	4	**13.33%↓***	0	0%	
Гүн үрчлээ тод илэрхий	2	**6.67%↓**	0	0%	
Маш гүн үрчлээ	0	0%	0	0%	

Зүүн нүдний гадна хажуу үрчлээнд нүүрний гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 30%, мэдэгдэхүйц үрчлээ 6.67%, өнгөц үрчлээ 3.33%, дунд зэргийн үрчлээ 16.67%, маш гүн үрчлээ 3.33%-аар үрчлээ багасаж, харьцуулах бүлэг болох нүүрний иллэгийн дараа 0% болж, хоёр бүлгийн хоорондох статистик ач холбогдол бүхий ялгаатай . (p=0.001***) байв. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Зүүн нүдний гадна хажуу үрчлээний нүүрний гуаша эмчилгээ болон иллэг заслын дараах харьцуулсан үр дүн

Үнэлгээ	Зүүн нүдний гадна хажуу үрчлээ				Р утга
	Гуаша эмчилгээний дараа		Нүүрний иллэг хийсний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	9	**30%↑*** **	0	0%	**0.001*** **
Мэдэгдэхүйц үрчлээ	2	**6.67%↓***	0	0%	
Өнгөц үрчлээ	1	**3.33%↓***	0	0%	
Дунд зэргийн гүн үрчлээ	5	**16.67%↓****	0	0%	
Гүн үрчлээ тод илэрхий	0	0%	0	0%	
Маш гүн үрчлээ	1	3.33%↓	0	0%	

Духны үрчлээнд нүүрний гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 40%, мэдэгдэхүйц үрчлээ 10% арилж, өнгөц үрчлээ 20%, дунд зэргийн үрчлээ 10%-аар үрчлээ багасаж, харьцуулах бүлэг болох нүүрний иллэгийн дараа үрчлээгүй 6.67%, мэдэгдэхүйц үрчлээ 0%, өнгөц үрчлээ 6.67%, дунд зэргийн үрчлээ 3.34%, гүн үрчлээ тод илэрхий 3.33%, маш гүн үрчлээнд 0% болж хоёр бүлгийн хоорондох статистик ач холбогдол бүхий ялгаатай . (p=0.001***) байв. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Духны үрчлээний нүүрний гуаша эмчилгээ болон нүүрний иллэгийн дараах харьцуулсан үр дүн

Үнэлгээ	Духны үрчлээ				Р утга
	Гуаша эмчилгээний дараа		Нүүрний иллэг хийсний дараа		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Үрчлээгүй	12	**40%↑**	2	6.67%↑	0.001***
Мэдэгдэхүйц үрчлээ	3	**10%↓**	0	0%	
Өнгөц үрчлээ	6	**20%↓**	2	6.67%↓	
Дунд зэргийн гүн үрчлээ	3	**10%↓**	1	3.34%↑	
Гүн үрчлээ тод илэрхий	0	0%	1	3.33%↓	
Маш гүн үрчлээ	0	0%	0	0%	

Хэлцэмж: Судлаач Жан Вэнь юань (2015) нарын судалгаагаар нүүрний үрчлээний бүлэгт 50 үйлчлүүлэгч сонгон авч гуаша эмчилгээ хийсэн ба судалгааны үр дүнд үрчлээний бүлэг 86.0% үр дүнтэй гэж тодорхойлсон бол бидний судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчид гуаша эмчилгээний дараа үрчлээгүй 19 (63.33%) үрчлээ арилсан, мэдэгдэхүйц үрчлээ 9 (30%), өнгөц үрчлээ 2 (6.67%) багассан статистик ач холбогдол (p= 0.0001***) үзүүлсэн нь бидний судалгаатай дүйж байна.

Мөн судлаач Ян Хай Ян (2017) нарын судалгаагаар нийт 60 тохиолдолд эмчилгээний бүлэгт гуаша иллэг эмчилгээг хавсарсан хийж, харьцуулах бүлэгт иллэг хийсэн судалгааны үр дүнд гуаша иллэг хавсарсан эмчилгээний бүлэгт 28 тохиолдол (93.33%), иллэгийн бүлэгт 20 тохиолдол (66.67%) үр дүнтэй байсан ба хоёр бүлгийг харьцуулахад гуаша эмчилгээний бүлэг нь үр дүн өндөртэй P<0.05 статистик ялгаа нь ач холбогдолтой байгаа нь бидний судалгааны 35-55 насны монгол эмэгтэйчүүдийн нүүрний үрчлээнд гуаша эмчилгээний үр дүнг иллэг засалтай харьцуулан судлахад нүдний гадна хажуу үрчлээнд үрчлээгүй 40%-аар үрчлээ арилж, мэдэгдэхүйц үрчлээ 13.33%, өнгөц үрчлээ 6.67%, дунд зэргийн үрчлээ 13.33%, гүн үрчлээ тод илэрхий 6.67%-аар багассан. (p=0.001***) Духны үрчлээнд үрчлээгүй 40%, мэдэгдэхүйц үрчлээ 10%, өнгөц үрчлээ 20%, дунд зэргийн үрчлээ 10%-аар багассан нь(p=0.001***) бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байна.

Талархал: Судалгааны ажилд хамрагдсан үйлчлүүлэгч болон судалгааг хийж гүйцэтгэхэд судалгааны орчин, нөхцөл судалгааг явуулах зөвшөөрөл боломжийг олгосон АШУҮИС, МАУОУСургуулийн багш нар, МАУҮТЭмнэлгийн хамт олонд гүнээ талархаж байна.

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн баруун болон зүүн нүдний гадна хажуугийн үрчлээ, духны хэсгийн мэдэгдэхүйц үрчлээ, өнгөц үрчлээнд гуаша эмчилгээ үр дүн өндөртэй болохыг тогтоов. Харин дунд зэргийн болон гүн үрчлээнд тодорхой хугацааны дараа үр дүн үзүүлсэн нь нэг курс эмчилгээ хангалтгүй байсан бөгөөд цаашид эмчилгээг үргэлжлүүлэн давтамжтайгаар хийвэл гүн үрчлээ арилгах төдийгүй урьдчилан сэргийлэх боломжтой юм.
2. Нүүрний гуаша эмчилгээ нь иллэгтэй харьцуулахад нүүрний үрчлээнд эмчилгээний үр дүн өндөртэй байгаа нь цаашид гуаша эмчилгээг арьсны хөгшрөлтийн эсрэг арьс, гоо сайханы чиглэлээр хэрэглэх эмчилгээний удирдамж гаргах боломжтойг харуулж байна.

Ном зүй:

1. *Jiechen Zhang, Wei Hou, Suying Feng, Xiangsheng Chen, Hongwei Wang. Classification of facial wrinkles among Chinese women.2017.https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC5445213/*
2. *Б.Хандсүрэн "Арьсны өвчин" 2010.x28-34*
3. *Gottfried Lemberle, M.D.,Ph.D.,Ralph E.Holmes,M.D., Steven R.Cohen,M.D., and Stefan M.Lemperle, M.D. A Classification of facial wrinkles. Plastic & Reconstructive Surgery. 2001; 1735-50*
4. *Dr Amanda Oakley Facial lines and wrinkles 2004.*
5. *Jeannie Khavkin, David A F Ellis https://pubmed.ncbi.nlm.nih.gov/21763983/*
6. *https://baike.baidu.com/m/%E9%9D%A2%E9%83%A8%E5%88%AE%E7%97%A7/6780652?fr=aladdin*
7. *Tsukahara K, et al.SkinResTechnol "The effect of eye opening and closing on the result of facial wrinkle assessment" 2009.*
8. *Tsukahara K, et al. Skin Res Technol "Gender-dependent differences in degree of facial wrinkles" 2013.*
9. *Tsukahara K, et al. J Dermatol Sci "Comparison of age-related changes in facial wrinkles and sagging in the skin of Japanese, Chinese and Thai women" 2007.*
10. *Gottfried Lemberle, M.D.,Ph.D.,Ralph E.Holmes,M.D., Steven R.Cohen,M.D., and Stefan M.Lemperle, M.D. A Classification of facial wrinkles. Plastic & Reconstructive Surgery. 2001; 1735-50*
11. *张文远1楚云杰2 "推拿结合砭石刮痧在面部美容中的应用效果" 2015 https://d.wanfangdata.com.cn/periodical/zgylmr201501094?fbclid=IwAR2QFawGAZ5OtzbJtnVb7FXxgu3rZaIuBcniKz0i_Z8OTwFdyv_Z4jGLLD4*
12. *"Facial Skin Aging Stages in Chinese Females"*
13. *杨海燕. 推拿结合砭石刮痧在面部美容中的应用效果. CNKI:SUN:RRJK.0.2017-08-109*

Results of guasha treatment for facial wrinkles

Bolorchimeg B[1], Enkhtur Ya[2], Bolortulga Z[1]

[1]International School of Mongolian Medicine, Mongolian National University of Medical Sciences
[2]Mongolian National University of Medical Sciences
E-mail: bolorchimeg.official@gmail.com, Tel: +976-99705008

Background: According to recent studies, women usually develop thin, small wrinkles starting at the age of 25, forehead wrinkles become deeper at the age of 30, and crow's feet appear in the upper and lower corners of the eyes. From the age of 40, the wrinkles on the mouth triangle become deeper. The facial guashe treatment of traditional Chinese medicine is an effective, and side-effect-free treatment for common skin conditions such as wrinkles on the face and neck, under-eye follicles, dark circles around the eyes, facial pigmentation, and acne. The facial guashe treatment heats the upper and lower layers of the skin and stimulates the production of new skin collagen and elastic fibers. It tightens the skin and reduces wrinkles. Although guashe treatment does not cause scarring or side effects on the skin of the face, researchers still intend to conduct further studies on its safety and its effectiveness. Therefore we conducted a study to evaluate the effects of facial guashe treatment on facial wrinkles in Mongolian women.

Aim: To study the effects of guasha treatment on facial wrinkles in Mongolian women

Objectives:

1. To study the results of guasha treatment for wrinkles on the forehead and outer side of the eyes in Mongolian women aged 35-55.
2. To study the results of massage therapy for wrinkles on the forehead and outside of the eyes.

Materials and Methods: The study was conducted in the outpatient department of the Central Hospital of the Mongolian National University of Medical Sciences. Statistical analysis was performed using SPSS 22. We took photographs of wrinkles using a mobile phone while sitting upright and evaluated them before and after treatment using a 5-point evaluation method (Lemperle scale). A total of 30 customers aged 35-55 years were treated with guasha treatment for wrinkles on the outer corner of the right eye and 30 customers were treated with facial massage 7-10 times, 15-20 minutes each time. Treatment was done 7-10 times (1 course of treatment).

Results: It was found that the total number of patients who had the right and left eye wrinkles declined. For example, the right eye's superficial wrinkles were reduced to 4 (13.33%), moderate deep wrinkles decreased to 3 (10%), and deep wrinkles declined to 0 (0%), which were statistically significant. (p= 0.0001). After the treatment of the left eye, 14 (46.67%) women's wrinkles disappeared. After the treatment for forehead wrinkles, the number of women without wrinkles increased by 40%, and superficial and moderate wrinkles decreased by 10%. After the facial massage therapy, the wrinkles of the eyes and forehead were not significantly decreased. (p=0.31 for right eye, p=1.0 for left eye, p=0.0625 for forehead).

Keywords: Guasha treatment**,** Facial massage, Mongolian women's facial wrinkles, Photographic scale